

ДАМПУУРЛЫН ШАЛТГААН, ТҮҮНД НӨЛӨӨЛЖ БҮЙ ХҮЧИН ЗҮЙЛИЙН СУДАЛГАА

С.Цолмон*, Д.Моломжамц**

Хураангуй: Энэхүү өгүүлэлд дампуурлын шалтгаан, компанийн дампууралд нөлөөлдөг гадаад ба дотоод хүчин зүйлийн нөлөөлөл, түүний нийгэм-эдийн засгийн үр дагаврын талаарх судлаачдын дэвшүүлсэн онол, арга зүй, үзэл баримтлалыг харьцуулан судалж дүгнэлт өгсөн болно.

Түлхүүр үгс: дампуурлын шалтгаан, гадаад хүчин зүйл, дотоод хүчин зүйл

STUDY OF BANKRUPTCY CAUSES AND ITS INFLUENCING FACTORS

Abstract: In this article, a comparison and a conclusion of the theories that the researchers made about the causes of bankruptcy, the external and internal factors that affect corporate bankruptcy, and its socio-economic consequences will be given.

Keywords: bankruptcy, causes of bankruptcy, external and internal factors

* МИС-ийн АТС, (E-mail): tsolmon@mandakh.edu.mn

** МУИС, Бизнесийн сургууль, (E-mail): molomjamts0112@yahoo.co.jp

Аливаа бизнесийн амжилт хийгээд дампуурал нь хоёр гол хүчин зүйл харилцан үйлчилсний үр дүн билээ. Нэгд, компанийн үйл ажиллагаа гадаад хүчин зүйлийн нөлөөнд орох ба энэ нь бизнесийн менежерүүдийн хяналтаас гадна байна. Эдийн засгийн өсөлт, инфляц, валютын ханш, хүүгийн хувь хэмжээ, хэрэглэгчдийн зан төлөв дэх өөрчлөлт, хандлага, сонголт, зах зээлийн үйл ажиллагааны үзүүлэлт дэх өөрчлөлт, бизнесийн ашигт үйл ажиллагаа болон зах зээлд эзлэх хувь хэмжээнд тодорхой хэмжээгээр нөлөөлж байдаг (Sharma & Mahajan, 1980).

Хоёрт, дотоод хүчин зүйл бөгөөд нь энэ нь компани дотор оршиж байгаа, компанийн хяналтад байдаг хүчин зүйл юм. Компанитай холбоотой хүчин зүйлсийн дотроос санхүүгийн өсөлтөд хангалтгүй хөрөнгө, хөшүүргийг хэт их хэрэглэх, байршил сонголтын алдаа, хэрэглэгчдийн хүлээлттэй нийцэж чадахгүй байх, үндсэн хөрөнгийн хөрөнгө оруулалтыг хэтрүүлэх зэргийг бизнесийн үйл ажиллагаанд нөлөөлөх дотоод хүчин зүйлс гэж үзнэ. Муу удирдлага нь дангаараа эдийн засгийн уналт, дараа нь санхүүгийн хүндрэлийн шалтгаан болж болно. Жишээлбэл; санхүүгийн хөшүүрэг хэт их байх нь эдийн засгийн уналт болохоос өмнө санхүүгийн хүндрэлийн шалтгаан болж болох юм (Whitaker, 1999). Тиймээс дотоод шалтгаан, их хэмжээний санхүүгийн хөшүүргийн үр дүнд үйл ажиллагаа унахыг удирдлагын чадамжтай холбож болно.

Олон улсын үнэлгээ тогтоодог агентлаг болох Дюн болон Брэдстрит (Dun & Bradstreet) дараах 5 үндсэн хүчин зүйлстэй холбогдсон бизнесийн уналтын судалгаа явуулсан байна (Robert, 1987). Үүнд:

1. Эдийн засгийн хүчин зүйлс,
2. Удирдлагын туршлага,
3. Борлуулалтын бууралт,
4. Зардлын өсөлт,
5. Бусад хүчин зүйлс зэрэг болно

Уг судалгаанаас үзэхэд бизнесийн уналтад нөлөөлөх гол хүчин зүйл нь эдийн засгийн хүчин зүйлс болон удирдлагын туршлага байна. Тиймээс компанийн дампууралд нөлөөлдөг гадаад, дотоод хүчин зүйлсийн шалтгааныг авч үзэх шаардлагатай.

Компанийн дампууралд нөлөөлөгч гадаад хүчин зүйлс: Компани бол үйл ажиллагаа явуулж буй тухайн улс орны эдийн засгийн нөхцөл байдалд өртөж, нөлөөнд орж байдаг эдийн засгийн нэгж билээ. Иймээс бизнесийн уналтын шалтгаан болж байдаг орчны зарим хүчин зүйлс хяналтаас гадна байна. Эдгээр хүчин зүйлсээс сэргийлэх боломжгүй хэдий ч сөрөг нөлөөг

багасгахын тулд зарим арга хэмжээг авах боломжтой. Бизнесийн уналтад нөлөөлдөг орчны хүчин зүйлсийг доор тайлбарлав.

Нийгмийн орчин: Бизнесийн уналтын гадаад шалтгааны нэг нь компанийн үйл ажиллагаа явуулж байгаа нийгмийн орчин юм. Энэ нь эдийн засгийн нөхцөл байдал, хүн амын бий болгосон зан төлөвийн шинж чанарын нэгдэл бизнесийн байгууллагын үйл ажиллагааг өөрчилдөг (Baker, Asikoglu, & Sevil, 1997). Бизнес амжилттай байхын тулд нийгмийн хүлээлтийг мэдэх, тэдгээр хүлээлтийн дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлж явуулах хэрэгтэй байдаг. Монополиос зайлсхийх, хэрэглэгчдийн эрх ашгийг хүндэтгэх, хүрээлэн буй орчныг ухамсарлах нь нийгмийн орчны зарим хүлээлт юм (Turko, 1999). Бослого үймээн хийгээд нийгмийн бусад үйл явдлууд, олон улсын харилцаа муудах, улс төр, нийгмийн нөхцөл байдал өөрчлөгдөх зэргийг компаниуд болон тэдгээрийн шийдвэр гаргах механизмд нөлөөлж байдаг нийгэм-улс төрийн эрсдэл гэж болно. Жишээ нь, 2001 онд Нью-Йорк дахь дэлхийн худалдааны төвийн сүйрлийн улмаас олон тооны тэргүүлэгч агаарын тээвэрлэгчид, даатгалын компаниудын хувьцааны ханш огцом унаж, компаниуд дампуурлын ирмэгт тулж байв. Тэдний нэг болох Swissair компани нислэгүүдээ зогсоож, дампуурах өргөдлөө өгч байхад эсрэгээр батлан хамгаалах, зэвсэг үйлдвэрлэлийн компаниудын үнэ цэнэ өссөн байна.

Салбарын орчин: Хүндрэлд орсон компаниуд ажиллаж байгаа салбарт өсөлт, бууралт тохиолдож болно. Эдгээр салбаруудын давлагаа олон компаниуд нөлөө үзүүлж болох тул санхүүгийн хувьд хүндэрч байгаа компаниуд уналтад хүргэх давлагаанд байнга өртдөг. Тухайлбал, тухайн салбарт байнгын тохиолддог ажил хаялт нь компаниудыг хүндрэлд оруулж үйлдвэрлэлийн шийдвэрийн утга учрыг алдагдуулна. Компаниудын хувьд салбарын эрсдэлд өртөх нь ихээхэн түгээмэл байдаг ба энэ нь компанийн гадаад орчинтой холбогддог. Үнийн эрсдэл нь нийт үнийн түвшин өсөх, буурах эсхүл салбар дахь үнэ огцом өөрчлөгдөх явдал ба энэ нь компаниудад хүндрэл бий болгож болзошгүй. Хөгжиж буй ихэнх улс оронд байдаг тогтворгүй эдийн засаг дахь инфляци нөлөө үзүүлдэг. Инфляци нь эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэр алдагдахаас үүсэх ба орлогын хуваарилалтыг гажуудуулж, хадгаламжийг сулруулан, монополийг нэмэгдүүлж, төлбөрийн тэнцвэрийг алдагдуулах ба эдгээр нь бүгдээрээ эдийн засгийг тогтворгүй болгодог. Үүний үр дүнд хөгжиж буй эдийн засагт компаниуд амархан хүндрэлд ордог байна (Egren, 1995). Хүүгийн хувь хэмжээ өндөр байх нь хөрөнгө оруулалтын зардлыг нэмэгдүүлж энэ нь хөрөнгө оруулалтын шийдвэрт сөргөөр нөлөөлөх тул ихэнх компаниудад хөрөнгө оруулалт хийгдэхгүй учир санхүүгийн хувьд сул болно. Ийм учраас ихэнх компаниуд өндөр инфляцтай үед хүндрэлд ордог байна. Тухайлбал, 1996 оноос харилцаа,

холбооны салбарт хөрөнгө оруулсан томоохон хөрөнгө оруулагчид энэ салбарт олон тооны өрсөлдөгчид бий болон үнийг унагасанд сэтгэл дундуур үлдсэн. Харилцаа холбооны компаниуд хөрөнгө оруулалтын хэрэгцээгээ хангахын тулд хувьцаа биш бонд гаргахыг илүүд үзсэн ба үүний үр дүнд тэдний өрөөрийн хөрөнгийн харьцаа 5-10 болжээ. Үүний дараа Моторолла, Эриксон компаниуд цомтгол хийхийг сонгож авсан ба Моторолла 22000 ажилчдаа халж, Эриксон 500 сая долларын алдагдал хүлээнээ зарласан. Интернетийн үйлчилгээ үзүүлэгч хамгийн том компаниудын нэг болох Пи Си Нет мөн 3.5 тэрбум долларын алдагдлаа зарлажээ. Эдгээр бүх үйл явдлаас гадна ихэнх том компаниудын зах зээлийн үнэ цэнэ ойролцоогоор 60-аас 90 хувь буурсан байна (Aydan, Alpan, Burzak, & Ataman, 2000).

Эдийн засгийн орчин: Бизнес бол эдийн засгийн системийн хэсэг бөгөөд үйл ажиллагаа явуулж буй улс орны эдийн засгийн нөхцөл байдалд өртөж байдаг. Эдийн засгийн хүчин зүйлс бизнесийн уналтад доор жагсаасан байдлаар нөлөөлж болох ба эдгээр нь: хүүгийн хувь хэмжээ гэнэт өсөх, буурах, инфляцийн түвшин санаандгүй өөрчлөгдөх, валютын ханш хэлбэлзэх, экспорт, импортын дэг хийгээд мөнгөний бодлогод өөрчлөлт орох явдал юм (Baker, Asikoglu, & Sevil, 1997). Нийгмийн хэрэгцээг хангахын тулд бизнесүүд бараа, үйлчилгээг зах зээлд нийлүүлдэг ба өөрөөр хэлбэл үйл ажиллагаагаа үргэлжлүүлж явуулдаг бөгөөд тэд нар хөдөлмөр, капитал, байгалийн баялаг зэрэг орцын хэрэгцээг тухайн зах зээлээс шаарддаг байна. Ихэнх тохиолдолд Засгийн газар төрийн эдийн засгийн чиг үүргийг тодорхойлогчийн үүрэг хүлээдэг. Чөлөөт зах зээлийн эдийн засагт Засгийн газрын үүрэг роль буурах хэдий ч улс орныг ирээдүйд хөтөлдөг макро-эдийн засгийн бодлогыг Засгийн газар тогтооно. Гадаад худалдааны бодлого, хүүгийн хувь хэмжээ, татварын зохицуулалт, санхүүгийн туслалцаа хийгээд дэмжих үйл ажиллагаагаар Засгийн газрууд бизнесийн үйл ажиллагаанд нөлөө үзүүлдэг (Demir, 1997) байна. Нэмэгдсэн өртгийн албан татварын хувь хэмжээ, гадаад худалдааны бодлого, гаалийн тариф, экспортын албан татвар дахь өөрчлөлт, хөрөнгө оруулалтын урамшууллын талаарх урьдчилан сэргийлсэн арга хэмжээ, гадаад валютын ханшид Засгийн газрын зүгээс интервенц хийх, цалингийн хамгийн бага хэмжээг тогтоох, ахмад настнуудад олгох нөхөн олговор, импортын хязгаарлалт, девальваци хийгээд макро-эдийн засгийн бусад хүчин зүйлүүд компанийн санхүүгийн нөхцөл байдалд эерэгээр болон сөргөөр нөлөөлж болно.

Байгаль орчин: Байгаль орчны хүчин зүйлс нь бизнесийн үйл ажиллагаанд амжилт олох зарим боломжийг бий болгохоос гадна бизнесийн уналтад нөлөөлж болох зарим хүндрэлийн шалтгаан болж байдаг. Байгалийн баялаг шавхагдах, хүрээлэн буй орчны бохирдол бизнесийн үйл ажиллагаанд

нөлөөлнө. Цаашлаад газар хөдлөлт, үеэр, түймэр, амьтны халдварт өвчин гэх мэт байгалийн гамшгийг бизнесийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлдөг байгалийн хүчин зүйлсийн жишээ гэж үзэж болно. Харамсалтай нь байгалийн гамшгийг тооцоолох, эсрэг арга хэмжээ авах нь туйлын хүнд юм.

Технологийн орчин: Технологи болон үйлдвэрлэлийн аргачлал дахь огцом өөрчлөлт нь эдийн засгийн чиглэлийн тодорхойгүй байдал, өрсөлдөөний эрчимжилтийг нэмэгдүүлдэг. Тиймээс өөрчлөлтөд дасан зохицох чадвар дутагдах, эдийн засгийн чиг баримжааг буруу тооцоолох нь ихээхэн хор уршигтай. Буруу технологид хөрөнгө оруулалт хийх нь эцэстээ компанийг санхүүгийн хүндрэлд оруулж болно. Технологиос үүдэлтэй бусад төрлийн эрсдэлүүдэд: суурь машин, үйлдвэрлэлийн аргаас шалтгаалсан осол, машин тоног төхөөрөмж эвдэрч, гэмтэх, бохирдол, химийн бодис, ашигласан технологийн радиаци зэрэг хүний эрүүл мэнд хийгээд орчинд нөлөөлөх хүлээгдээгүй нөлөөлөл.

Хууль, улс төрийн орчин: Бизнесийн үйл ажиллагаанд дагаж мөрдөх зарим хууль тогтоомжийн (Худалдааны хууль, Татварын хууль, Үүргийн хууль, Дампуурлын хууль гэх мэт) өөрчлөлт нь компанийн дампууралд нөлөөлж болно. Бизнесүүд эдгээр хуулийг зөрчих нь төрөл бүрийн торгууль төлж, нэр хүндээ алдах учир эдгээр сөрөг зүйлүүд бизнесийн уналтын шалтгаан болдог.

Компанийн дампууралд нөлөөлөгч дотоод хүчин зүйлс: Компанийн дампуурах дотоод шалтгаан нь удирдлагын ур чадваргүй байдалтай шууд холбоотой. Чикагод байрлах Buccino & Associates, зөвлөх үйлчилгээний компаниас 1991 онд явуулсан судалгаагаар оролцогчдын 88 хувь нь компанийн удирдлагын хүчин зүйлс нь компанийн амжилт болон уналтыг тодорхойлох үндсэн шалтгаан гэж үзжээ. Мөн 1980 онд хийсэн D&B-ийн судалгаанд компанийн дампуурлын 44 гаруй хувь нь удирдлагын мэдлэг, туршлага дутсантай холбон тайлбарласан байна.

D&B-ийн судалгаатай адил дүгнэлтэд хүрсэн судлаач болох Л.Ж.Житманы үзэж байгаагаар 50 гаруй хувь нь удирдлагатай холбоотой байгааг олж тогтоосон (Gitman, 2009).

1999 онд Б.Дурукан болон П.Эвмир нар хамтран дампууралд нөлөөлдөг зарим дотоод хүчин зүйлийг хураангуйлсан байна. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын дутагдалаас шалтгаалж капиталын оновчтой бүтэц алдагдах,
- Зах зээлийн шинжилгээг хангалтгүй хийх,
- Зардал ихээс шалтгаалж үйл ажиллагааны эхний үед өрсөлдөх чадвараа алдах,
- Үйлдвэрлэлийн буруу арга сонгох,

- Үйлдвэрлэлийн зардлыг өндөр болгодог технологи сонгох,
- Үр ашиггүй ложистик,
- Патент, лиценз, франчайз, гэрээ зэргээс шалтгаалан гаднаас хамааралтай байх,
- Үндсэн хөрөнгөнд их хэмжээгээр хөрөнгө оруулалт хийснээс үйлдвэрлэлийн хүчин чадал оновчтой хэмжээнд хүрч чадахгүй, үр ашиггүй байх,
- Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, суурь машиныг зохисгүй байрлуулах,
- Хөрөнгө оруулалтын төсөл чанаргүй хийгдэх,

Бизнесийг бий болгосны дараа туршлагагүй удирдлага бизнес хийж байгаа үед тохирохгүй зарим хүмүүсийг авч ажиллуулах нь эрсдэл дагуулдаг. Тохирохгүй байдлын зарим гол шинжийг дараах байдлаар тодорхойлсон байна:

- Огцом өсөлтийн улмаас оруулсан хөрөнгө дутагдах, хөшүүргийн хольц их байх;
- Санхүүгийн төлөвлөлт, хөрөнгийн эх үүсвэр тэнцвэргүй байх;
- Тогтмол зардал төлөвлөснөөс өндөр түвшинд байх;
- Авлагаа хугацаанд нь авч чадахгүй байснаас найдваргүй авлага нэмэгдэх;
- Бараа материалын муу менежмент;
- Үйлдвэрлэлийн зардлын түвшин өндөр, тэдгээрийг хянаж чадахгүй байх;
- Хангалтгүй борлуулалт;
- Зах зээлийн судалгаа, зах зээл байршуулалтыг хайхрахгүй байх;
- Менежерүүдийн хооронд нийцэл бий болгож чадахгүй байх;
- Менежерүүдийн техникийн мэдлэг тааруу байх;
- Зардлыг бууруулах тохиромжтой аргыг ашиглаж чадахгүй байх;
- Байгууллагын нэгжүүдийн дунд хамтын ажиллагаа алдагдах;
- Шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг эхлүүлж чадахгүй байх;
- Эрх мэдэл, харицлага хоорондын тэнцвэргүй байдал

Дюн болон Брэдстрит нар санхүүгийн хүндрэлд орж буй компанийн насжилтын талаар сонирхолтой статистик гаргасан бөгөөд туршлагагүй удирдлага болон дампуурал хоорондын хамаарлыг гаргажээ. Туршлагагүй, залуу, бага хөрөнгөжсөн компанийн уналтын шалтгаан нь байгуулагдаад удсан компанийг бодвол илүү байна. Энэ статистикаар бүх уналтын 50 гаруй хувь нь

байгуулагдаад эхний 5 жил болсон компаниудад тохиожээ. Таван жилийн дараа уналтын хувь хэмжээ багасаж, компаниуд илүү тогтвортой, туршлагжсан, хөрөнгө олж авах чадвар нь сайжирсан байдаг байна (Altman E. , 1993).

Бизнесийн амьдралын мөчлөг ба компанийн дампуурал: Бизнесийн амьдралын мөчлөг бол бизнесийн уналтын нөгөө талыг тодотгож өгдөг гадаад, дотоод хүчин зүйлсэд шууд нөлөө үзүүлдэг бас нэг тал болно. Хэдийгээр компани хязгааргүй хугацаагаар оршин тогтнох учиртай ч бодит байдал дээр энэ нь тэр бүр биелдэггүй. Бизнесийг амьдралын мөчлөгөөр нь дөрөв ангилэх ба эдгээр нь үүсэж бий болох, өсөх, биежих, уруудах гэхчлэн зах зээлд шинэ бүтээгдэхүүнийг ангилдагын адилаар авч үзнэ. Бизнесийн амьдралын мөчлөгийг үүсэж бий болох үе шатанд буюу компани шинээр байгуулагдаж, салбарт орох, өөрийгөө танилцуулахыг зорих зэргийг урагшаа чиглэдэг гэдгийг дуухас дурдсан. Борлуулалтын хэмжээ бага байвал харалдаа байх ашиг байхгүй. Өсөлтийн үе шатанд борлуулалтын хэмжээ тогтвортой нэмэгдэх учир ашиг алгуурхнаар нэмэгдэж хамгийн дээд хэмжээнд очно. Биежих үе шатанд өрсөлдөгчдийн тоо нэмэгдэж, хатуу ширүүн өрсөлдөөний улмаас ашгийн түвшин бага зэрэг багасдаг.

Борлуулалтын түвшин бага зэрэг буурч, оргил үедээ хүрэх тул хэсэг хугацааны дараа борлуулалт, ашиг хамт унана. Бууралтын үе шатанд компани үр ашигтай байдлаас алдаж, борлуулалтын хэмжээ, ашиг нь компани цаашид оршин тогтнож чадахгүй болдог. Эдгээр үе шатууд эхлэхэд, төгсгөл субъектив утгаараа болох хэдий ч И.Мусук зэрэг зарим судлаачид эдгээр үе шатуудыг тогтоох объектив шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулжээ (Mucuk, 1994). Амьдралын мөчлөгийн таамаглал нь өсөлтийн үе шатанд үр дүнтэй удирдлага байдаг, харин биежих үе шатанд хангалтгүй удирдлага байдаг тул амьдралын мөчлөгийн дагуу бууралтаар загварчлагдаж болно. Тиймээс, удирдлагын гол зорилго бол өсөлтийн үе шат руу чиглүүлэх, бууралтын үе шатнаас сэргийлэх явдал юм. Бизнес өсөлтийн үе шатанд байхад бизнесийн удирдлага шинэ бүтээгдэхүүнийг танилцуулах эсхүл өсөлтийг хадгалах хамгийн оновчтой шийдвэрийг гаргахын тулд орчны нөхцөл байдлыг анхаарч үзэх ёстой бөгөөд ингэснээр бизнес өсөлтийн үе шатанд илүү удаан хугацаагаар байж болно (Wheelen & Hunger, 2000).

Компанийн дампуурал нь тухайн улсын нийгэм, эдийн засагт хэд хэдэн сөрөг үр дагаврыг бий болгодог байна. 1930 оны дэлхийн санхүүгийн хямралын үед урьд өмнө нь тохиож байгаагүй олон аж ахуй нэгж дампуурсан. Аж ахуйн нэгжийн дампуурал нь компанийн удирдлага, хувьцаа эзэмшигч, ажилтнууд, зээлдүүлэгч, үйлчлүүлэгчид болон бусад оролцогч талуудын хувьд хамгийн чухал асуудал юм. Мөн дээрх талуудаас гадна тухайн улсын нийгэм, эдийн

засагт үзүүлэх сөрөг нөлөө нь шууд болон шууд бус байдлаар илэрч байдаг (Altman E. , 1968). Үүнийг бид аль ч улсын түүхэнд тохиож байсан томоохон хэмжээний санхүү, эдийн загсийн хямралын үеийн нийгэм, эдийн засагт тохиосон олон арван бодит жишээнээс харж болно.

Аж ахуй нэгжийн өрсөлдөөн, дампуурал нь зах зээлийн харилцаанд зайлшгүй байх нийгмийн үзэгдэл боловч түүнийг заавал байх ёстой хэмээн төрөөс зөнд нь орхих биш эрх зүйн зохицуулалт шаардлагатай байдаг. Учир нь дампуурал нь улс орон ард түмний хувь заяатай холбоотой бүхий нийгмийн сөрөг үзэгдэл тул дампуурлаас урьдчилан сэргийлэх, нэгэнт дампуурсан бол түүний эцэст гарсан үр дагаврыг арилгах арга хэмжээ авдаг. Тухайлбал, хуулийн этгээд дампуурсны улмаас олон хүн ажилгүй болох, харилцагч зарим тал өр төлбөрөө бүрэн авч чадахгүйд хүрэх, зах зээл дэх өрсөлдөгчдийн тоо цөөрөх, ингэснээрээ зах зээлийн нийлүүлэлт буурах зэрэг сул талтай.

Макро эдийн засгийн үндсэн асуудлын нэг болох ажилгүйдлийн хувь хэмжээ нь компанийн дампууралтай шууд холбоотой. Тэр үед хуучин үйлдвэрлэж байсан бараа, үйлчилгээ цаашид үйлдвэрлэгдэхгүй болж алдагдал бий болох ба салбарын хүчин чадал ашиглалт буурдаг. Үүнтэй адилаар дампуурсан компанид хөрөнгө оруулагчид өөрсдийн хуримтлалаа компани өргөжин тэлэхэд шаардагдах хөрөнгө босгодог хөрөнгийн зах зээлд байлгах эсэхдээ эргэлзэх болно.

Зарим улс оронд дампуурсан компанийн нэр хүнд унахаас гадна тухайн компанид ажиллаж байсан удирдлага, ажилчдын хувьд сэтгэл санаагаар унах, амиа хорлох, өөр газар ажилд орох боломжгүй болох зэрэг асуудлууд үүсдэг байна. Тухайлбал, Европын олон улс оронд бизнес дампуурахад тэрхүү компанийн эзэн төдийгүй тэнд ажилладаг хүмүүсийн хувьд туйлын ичгэвтэр байдалд ордог. Дампуурсан компанитай ямар нэгэн хэлбэрээр холбоотой байсан хүмүүст шинээр ажил олоход бэрх байх тохиолдол байдаг. Мөн АНУ-ын Төрийн Департамент, Олон улсын мэдээллийн хөтөлбөрийн товчооны “Бизнесийн самбаачлал ба жижиг бизнес” тайлангаас үзвэл Япон улсад санхүүгийн дампуурлын гутамшигт байдал нь хүмүүсийг амиа хорлоход хүргэдэг талаар дурдсан байна (Олон улсын мэдээллийн хөтөлбөрийн товчоо, 2006). Харин зах зээл хөгжсөн зарим оронд аж ахуй нэгжийн дампуурал нь нийгэмд сөрөг нөлөөлөл үзүүлэхийн зэрэгцээ бас эерэг талтай гэж үзэх явдал байдаг. Өөрөөр хэлбэл чанаргүй бүтээгдэхүүн үйлдвэрлэж хэрэглэгчээ хохироодог, бусдын өмнө эрх эдэлж, үүрэг хүлээх чадваргүй, өөрөөр хэлбэл жинхэнэ аж ахуйн нэгж шиг ажиллаж чадахгүй бол дампуурах нь зүйтэй гэдэг философи үйлчилж байдаг.

Мөн өнөөгийн уналт нь маргаашийн амжилтыг дагуулна буюу дампуурч

байж томоохон хэмжээний амжилтад хүрдэг гэсэн бичигдээгүй хууль зарим эдийн засагч, судлаачдын дунд байдаг нь оргүй зүйл биш юм. Тухайлбал, Жон Хенри Хайнц, Форд Мотор компанийн эзэн Хенри Форд, Америкийн цирк үүсгэн байгуулсан Финеас Барнум зэрэг өнөө үеийн тун амжилттай явж буй олон бизнесмений эхний бизнес нь бүгд дампуурч байсан. Эдгээр хүмүүст бизнес эрхлэх, дампуурсан ч шинээр эхлэх нөхцөл боломжийг нь бүрдүүлж өгсөн тул тэд яваандаа маш баян хүмүүс болсон олон жишээ байна.

С.Бюхлер, Ц.Кайзер болон Ф.Жегер нарын судалгаанд дампуурлын хувь хэмжээ өндөр байдаг салбар, бүс нутагт компаниуд нэгдэх үйл ажиллагаа ховор байдаг гэдгийг дурдсан (Buehler, Kaiser, & Jaeger, 2006). Өөрөөр хэлсэн бас нэг өөр судалгаанд томоохон компаниуд хоорондоо нэгдэх нь жижиг компаниуд хоорондоо нэгдэхийг бодвол илүү түгээмэл байдаг гэжээ. Цаашлаад компанийн насжилт бол нэгдэх хийгээд дампуурах явцын бас нэг чухал хүчин зүйл гэдгийг гаргасан байна. Тэд компаниудын дампуурал болон нэгдэлтийн тохиолдол нь компанийн насжилттай урвуу хамааралтай гэдгийг олжээ. Макро-эдийн засгийн өсөлтийн үед нэгдэх үйл ажиллагаа нэмэгдэж, дампуурал, сайн дурын татан буугдах нь багасдаг байна. Өрсөлдөгч компани дампуурлаа зарлах нь тухайн салбарт үйл ажиллагаагаа явуулж байгаа бусад компаниудын хувь бас хэцүү бэрх зүйл. Өрсөлдөгч компанийн дампуурал нь тухайн компанийн өрсөлдөгчдөд эерэг үйл явдал мэт харагдаж болох юм. Энэ үйл явдлыг утга зохиолд өрсөлдөөний нөлөө гэж томъёолсон байдаг. Өрсөлдөөний нөлөөгөөр өрсөлдөгч компанийн дампуурал нь бусад компанид зах зээлд эзлэх хувь хэмжээ нэмэгдэх, тэдний хувьцааны үнэ зах зээлд нэмэгдэх зэргээр нөлөөлнө. З.Икбал болон С.Шетти нар судалгаандаа 1991-1996 оны үед Америкт нэг компани санхүүгийн хүндрэлд орсноор хөрөнгийн өгөөжид эерэг нөлөө үзүүлж байгааг илрүүлжээ (Iqbal & Shetty, 2002). Өрсөлдөгч компанийн дампуурлын талаарх мэдээ нь тухайн салбарт ажиллаж байгаа бусад компаниудад ижил асуудлуудыг бий болгодог гэдгийг Г.Катон, Ж.Дональдсон болон Ж.Гох зэрэг судлаачдын судалгаа баталсан байдаг (Caton, Donaldson, & Goh, 2008). Бусдад нөлөөлөх байдлаар, өрсөлдөгч компани дампуурлаа зарлах нь салбарын талаар өөдрөг бодол бий болоход сөргөөр нөлөөлдөг байна. Санхүүгийн хүндрэл нь тухайн компанийн удирдлага, ажилчидад төдийгүй тухайн салбарт үйл ажиллагаа явуулж буй бусад өрсөлдөгч компаниудад ч мөн салбарын өөдрөг өсөлтөд итгэх итгэлийг бууруулаад байна. С.Ферис болон А.Махиджа зэрэг эрдэмтэд судалгаандаа санхүүгийн хувьд хүндэрсэн компанийн өрсөлдөгч компаниудын хувьцааны өгөөж эхний гурван хоногийн дотор ойролцоогоор 4.68% буурсныг тогтоожээ (Ferris & Makhija, 1997). Энэ нь салбарын талаар сөрөг мэдээлэл тархдаг гэдгийн нэгэн баталгаа юм.

А.Канес Их Британи, АНУ, Испани болон Швейцарь улсын банкны салбарт үйл ажиллагаагаа явуулдаг үндэстэн дамнасан банкны бүлэг болох ВССI-ийн дампуурлын нөлөөг шинжилжээ (Kaplan, 2004). Канас банкны дампуурал нь Британи болон Испанийн банкны салбарт бусдад нөлөөлөх байдалд орсон гэдгийг тогтоов.

Санхүүгийн хямралын бусдад нөлөөлөх байдлын талаарх бас нэг сонирхолтой судалгааг Г.Гай, Г.Стивен болон К.Янг нар хийсэн байна (Gay, Stephen, & Yung, 1991). Энэхүү судалгаанд Хонг-Конгийн дампуурсан гурван банк, Хонг-Конгийн банкны салбарын хувьцааны үнийн нөлөөллийг шалгасан байна. Компанийн санхүүгийн хүндрэл нь бүхэл бүтэн нийгэмд сөргөөр нөлөөлөх бололцоотой. Тиймээс компаниудын хувьд эрт анхааруулах системийг бий болгож, хөгжүүлэх нь чухал ач холбогдолтой. Ийм байдлаар боломжит уналтуудыг эргүүлж, үр дүнд нь компаниуд дахин зохион байгуулалт хийх боломжийг бий болгоно.

Дүгнэлт

Энэхүү сэдвийн хүрээнд судлагдсан эрдэмтэн, судлаачдын бүтээлд тулгуурлан компанийн дампуурал, түүний үндсэн шалтгаан, дампуурлыг урьдчилан таамаглахын ач холбогдол, компанийн дампууралд нөлөөлөгч хүчин зүйлсийг судалж дараах дүгнэлтэд хүрч байна. Үүнд:

- Нийгэм, эдийн засаг, салбар, байгаль орчин, технологи, хууль, улс төрийн орчны нөлөө их байдаг гэж үздэг ба гадаад орчны хүчин зүйлээс шалтгаалан санхүүгийн хүндрэлд орсон үед тухайн компани ямар нэг хариу үйлдэл үзүүлэх боломж сул байдаг тул төрийн бодлого чухал үүрэгтэй. Тэр дундаа компаниудын бизнесийн туршлага, зах зээлийн цар хүрээ бага, зээлийн хүү, татварын дарамт өндөртэй манай улсад төрийн үүрэг оролцоо чухал гэж үзэж байна;
- Компанийн дампууралд нөлөөлөгч дотоод орчны үзүүлэлтэд удирдлагын ур чадвар сул, өрсөлдөөн, засаглал, хяналт шалгалт, төлөвлөлт зэрэг тухайн компаниас шалтгаалах хүчин зүйлс байгаа тул удирдлагын зүгээс компанийн дампуурлыг урьдчилан таамаглаж, оновчтой шийдвэр гаргах замаар санхүүгийн эрсдэлээс сэргийлэх бүрэн боломжтой гэж дүгнэж байна.

Ашигласан материал

Altman, E. (1968). Discriminant Analysis and the Prediction of Corporate Bankruptcy. *The Journal of Finance*, pp. 589-609.

- Altman, E. (1983). *Corporate financial distress: A complete guide to predicting, avoiding, and dealing with bankruptcy*. New York:: John Wiley & Sons.
- Altman, E. (1993). *Corporate financial distress: A complete guide to predicting, avoiding and dealing with bankruptcy, second edition*. New York: John Wiley and Sons.
- Altman, E. (2002). *Bankruptcy, credit risk, and high yield junk bonds: a compendium of writings*. Oxford:: Blackwell Publishing.
- Altman, E. (2006). *Corporate financial distress and bankruptcy: Predict and Avoid Bankruptcy, Analyze and Invest in Distressed Debt. Third Edition*. . Hoboken, New Jersey: John Wiley & Sons, Inc.
- Altman, E. I., Haldeman, R. G., & Narayanan, P. (1977). ZETA Analysis. A new model to identify bankruptcy risk of corporations. *Journal of Banking and Finance* , Vol.1, 1977, pp. 22E54.
- Altman, E. I., Marco, G., & Varetto, F. (1994). Corporate Distress Diagnosis: Comparisons Using Linear Discriminate Analysis and Neural Networks. *Journal of Banking and Finance*, 18, 505–529.
- Altman, E., Iwanicz-Drozdowska, M., Laitinen, E. K., & Suvas, A. (2014). Distressed Firm and Bankruptcy prediction in an international context: a review and empirical analysis of Altman's Z-Score Model.
- Aydan, A., Alpan, I., Burçak, T., & Ataman, P. (2000). Bankacılık Sisteminde Mali Bünye Sorunları Ve Yeniden Yapılandırma Ülkeleri Uygulamaları. *Bankacılar Dergisi*, 22.
- Buehler, S., Kaiser, C., & Jaeger, F. (2006). Merge or Fail? The Determinants of Mergers and Bankruptcies in Switzerland, 1995 - 2000, . *Economics Letters*, 90, 88- 95.
- Buker, S., Asikoglu, R., & Sevil, G. (1997). *Finansal Yönetim, 2. Edition*., Anadolu Üniversitesi, Eskisehir.
- Caton, G. L., Donaldson, J., & Goh, J. (2008). The Effect on Rivals When Firms Emerge from Bankruptcy. . *Corporate Ownership and Control*, 6(2), 304-311.
- Demir, H. (1997). İşletmelerde Başarısızlığın Nedenleri ve Çıkış Yolları, *Dış Ticaret Dergisi*,6
- Durukan, B., Özkol, E., Yücel, T., Baklacı, H., Evrim, P., Özkan, S., Başoğlu, S. (1999). *Finansal Yönetim*, İzmir.
- Eren, S. (1995). *Para ve Para Politikası*. Beşinci Basım. İstanbul: Gerçek

Yayınevi.

- Ferris, S. J., & Makhija, A. (1997). The Response of Competitors to Announcements of Bankruptcy: An Empirical Examination of Contagion and Competitive Effects. *Journal of Corporate Finance*, 3(4), 367-395.
- Gay, G., Stephen, G., & Yung, K. (1991). Bank Failure and Contagion Effects: Evidence from Hong Kong. *Journal of Financial Research*, 14(2), 155-165.
- Iqbal, Z., & Shetty, S. (2002). Insider Trading and Stock Market Perception of Bankruptcy. *Journal of Financial Economics and Business*, 54(5), 525-535.
- Gitman, L. J. (2009). *Principles of Managerial Finance, 12. Edition*. Person Prentice.
- Kanas, A. (2004). Contagion in Banking Due to BCCI's Failure: Evidence from National Equity Indices. *International Journal of Finance and Economics*, 9(3), 245-255.
- Mucuk, I. (1994). Pazarlama İlkeleri. Altıncı Basım. İstanbul: Der Yayınları.
- Robert, M. (1987). Dun & Bradstreet sets its own speed limits. *Planning review*, vol. 15, Iss.2.
- Sharma, S., & Mahajan, V. (1980). Early Warning Indicators of Business Failure. *Journal of Marketing*, 44(4), 80-89.
- Turko, R. (1999). Finansal Yönetim. Alfa Yayın, İstanbul.
- Wheelen, T. L., & Hunger, J. D. (2000). *Strategic Management: Business Policy. Prentice Hall, 7. Edition*. New Jersey.
- Whitaker, R. (1999). The Early Stages of Financial Distress. *Journal of Economics and Finance*, 23(2), 123-133.